



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ, №04

2019.03.01

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хүн ба шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2019 оны 02-р сарын 16-аас 03-р сарын 01-ний байдлаар Дэлхийн улс орнуудад А хүрээний вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөл бүртгэгдээгүй ба шувууны өвчлөлийн нийт 5 удаагийн дэгдэлт Хятад (1), Тайвань (4) улсад бүртгэгдсэн байна (Хүснэгт 2).

ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусийн хүний өвчлөл ба нас баралтын дэлгэрэнгүй мэдээлэл:

2003 оноос 2019 оны 03-р сарын 01-ний хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусийн 860 тохиолдол бүртгэгдсэнээс 454 (52.7%) нь нас барсан бөгөөд сүүлийн тохиолдол 2017 оны 9-р сарын 26-нд Индонези улсад 1 тохиолдол бүртгэгдэж нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд 238 тохиолдол бүртгэгдсэнээс 134 (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусийн халдвартын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2019 оны 03-р сарын 01

Улс	2003-2013		2014		2015		2016		2017		2018		2019		Нийт	
	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н
Камбожи	47	33	9	4	0	0	0	0	0	0	0	0	0	0	56	37
Хятад	45	30	2	0	6	1	0	0	0	0	0	0	0	0	53	31
Лаос	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	2
Вьетнам	125	62	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	127	64
Нийт	219	126	13	6	6	1	0	0	0	0	0	0	0	0	238	134

Тэмдэглэгээ: (Т)-тохиолдол; (Н)-нас баралт

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2019 оны 03-р сарын 01-ний байдлаар шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лабораториор батлагдсан нийт **23** тохиолдлоос **7** (30.4%) нь нас барсан.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2019 оны 03-р сарын 01-ний байдааар шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2018 оны 2-р сарын 14-нд хүний өвчлөлийн анхны тохиолдол БНХАУ-ын Жинсу мужад бүртгэгдсэн талаар ДЭМБ-аас мэдээлж байсан.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2019 оны 03-р сарын 01-ний байдааар шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн нийт **1567** тохиолдол лабораториор батлагдсан.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2019 оны 03-р сарын 01-ний байдааар шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2013 оны 12-р сараас хойш БНХАУ-д хүний өвчлөлийн **23** тохиолдол бүртгэгдсэн.

ДОЛОО. Шувууны томуугийн вирусийн шувууны өвчлөлийн мэдээлэл:

Хүснэгт 2.

2019 оны 02-р сарын 16-аас 03-р сарын 01-ний байдлааар

Үлс	Ортөмхий	Үхсэн	Устгасан	Тайлбар
A (H5N2) вирусийн шувууны өвчлөл				
Тайвань /Хятад/	65496	4260	61236	Шувууны ферм
A (H5N6) вирусийн шувууны өвчлөл				
Хятад	56380	463	55917	Шувууны ферм
НИЙТ	121876	4723	117153	-

Албан ёсны эх сурвалж:

- http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber_H5N1cases.pdf
- http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m
- http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1
- <http://empres-i.fao.org/eipws3g/#h=0>

ЗӨСҮТ

ЭУББТСТ

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ